



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 16,860,135 (арван зургаан сая найман зуун жаран мянга нэг зуун гучин тав) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургууль (Л.Амартуяа)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургууль (Л.Амартуяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000247

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2022 оны 03 дугаар сарын 11 -ны
өдрийн 4/87 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Таблет	Samsung s6 lite, 64 GB	2022	сайн	ш	15	1,124,009	16,860,135	Нийслэлийн Боловсролын газар, Сөүл хотын Боловсролын газрын хооронд хамтран ажиллах Санамж бичиг	Буцалтгүй тусламж
Бүртгэх тоног төхөөрөмжийн нийт дүн								16,860,135		